



УЛААНБААТАР ТЕАТР ОНӨТҮГ ДАРГЫН ТУШААЛ

dodd оны 02 сарын 15 өдөр

Дугаар *A/32*


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар театрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн "захиргааны зөвлөл"-ийн хурлын шийдвэрийг үндэслэн Улаанбаатар театрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай "Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний журам"-ыг тус тушаалын хавсралтаар шинэчлан баталсугай.
2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/11 тоот тушаалыг хүчингүй болгосугай.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг "Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн М.Энхтуулд үүрэг болгосугай.





Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг зохион байгуулах журам

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь Улаанбаатар театрин үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулахдаа Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсний үндсэн дээр Даргын тушаалаар мөрдүүлнэ.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ

2.1 Дотоодын хяналт шалгалтын зорилго нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, Монгол улсын хууль, тогтоомж, дүрэм журам, норм стандарт нийцэж байгаа эсэх болон Нийслэлийн Засаг Даргын мэрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, үндсэн чиглэлийн мөрдөж ажиллахад хяналт тавьж, аливаа гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөмж өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцож, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчинд аюул осолгүй үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулахад чиглэнэ.

Гурав. Байгууллагын дотоод хяналт

3.1 Дотоод хяналт шалгалтыг дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн зохион байгуулна.

3.2 Театрын даргын тушаалаар дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэнг томилон ажиллуулах бөгөөд тухайн ажилтан хууль эрх зүй болон байгууллагын үйл ажиллагааны онцлогийн талаар зохих мэдлэгтэй, ажлын дадлага туршлагатай байвал зохино.

3.3 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ. Хяналт шалгалтын төлөвлөгөөг жилд 1 удаа, хяналт шалгалтыг улиралд 1 удаа, удирдамжийг тухай бүр боловсруулан батлуулна.

3.4 Дотоод хяналт шалгалтын ажилтан хяналт шалгалтын үр дүн, авсан арга хэмжээнийхээ талаар жилд 2-оос доошгүй удаа даргад танилцуулж, шийдвэр гаргуулан шаардлагатай тохиолдолд хамт олонд мэдээлнэ.

3.5 Театрын уран бүтээлийн нэгж, тайзны нэгж, захиргааны нэгжийн үйл ажиллагааны үр дүнд явцын болон гүйцэтгэлийн хяналтыг тогтмол хийж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх. Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст холбогдох тайлан мэдээг хүргүүлэх.

3.6 Театрын удирдлага дотоод хяналтын ажилтны ажил үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгаж өгсөн байна.

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын ажилтны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

4.1 Улаанбаатар театрин үйл ажиллагааны хүрээнд мөрдөж буй дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамжийн дагуу нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, даргад танилцуулан шийдвэр гаргуулах;

4.2 Учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж зөвлөгөө өгөх, эрсдэлийг тодорхойлж үнэлэх, боловсронгуй болгох зөвлөмжийг өгч ажиллах;

4.3 Театраас гаргасан бодлого, журам, заавар, тушаал шийдвэр нь Монгол улсын хууль тогтоомжид нийцэж, үр дүнтэй, зохистой байгаа эсэхийг хянах;

4.4 Монгол улсын хууль, тогтоомж, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төслийн хэрэгжилт, байгууллагын дүрэм, дотоод журмаар хүлээсэн үүргийн хүрээнд дараах чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулна. Үүнд:

4.4.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлж буй захирамжлалын баримт бичиг, албан хэргийн шийдвэрлэлт, иргэд аж ахуй албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, байгууллагын архив, бусад эрх зүйн бичиг баримтын хэрэгжилт;

4.4.2 Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага байгууллагын дотоод журмын биелэлт;

4.4.3 Ажилтан, албан хаагчийн ажиллах журам болон ажиллагсдын ёс зүйн дүрмийн хэрэгжилт;

4.4.4 Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалт;

4.4.5 Ажилтан, албан хаагч, уран бүтээлчдийн төлөвлөгөөт ажлын явцад хяналт шалгалт хийх

Тав. Дотоод хяналт шалгалтын ажилтны эрх, үүрэг

5.1 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь дараах эрхтэй. Үүнд:

5.1.1 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь театрын даргын шууд удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад нэгжээс хараат бус байна.

5.1.2 Хяналт шалгалтыг явуулахдаа ажилтан, албан хаагч, уран бүтээлчидтэй шууд харилцаж тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, илэрсэн зөрчлийн талаар тайлбар гаргуулах;

5.2 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь дараах үүрэгтэй. Үүнд:

5.2.1 Батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах;

5.2.2 Илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах, зөрчил гаргасан этгээдэд заавар зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд хариуцлага ноогдуулах талаар удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

5.2.3 Монгол улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэр, Нийслэлийн Засаг дарга болон дээд газруудын тушаал шийдвэрийг өөрийн байгууллагад хэрэгжүүлэх талаарх сургалтыг холбогдох албан тушаалтнуудтай хамтран зохион байгуулах;

5.2.4 Театрын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох талаар судалгаа дүгнэлт гаргах;

5.2.5 Дотоод хяналтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийн нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад хэлж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан даргад танилцуулах

5.2.6 Театрын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах;

5.2.7 Шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийг бүртгэх, дотоод хяналт шалгалтын чиглэлийн материалыг хөтлөлт хийн, мэдээллийн сан бүрдүүлж байгууллагын архивт нэгж болгон хүлээлгэн өгөх;

5.2.8 Дотоод хяналтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хохирол учруулж болохуйц, нөхцөл

байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

5.2.9 Дээрх эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын ажилтанд дарамт шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглох;

5.2.10 Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн нь ажил үүргээ үнэнч шударгаар идэвх зүтгэлтэй, санаачлагатай гүйцэтгэж байгаа ажилтанг шагнаж урамшуулах саналаа театрын даргад өгөх;

Зургаа. Хариуцлага

6.1 Дотоод хяналт шалгалтаар зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам болон ёс зүйн дүрэмд заасан арга хэмжээ авах саналыг театрын дарга, Захиргаа болон Уран сайхны зөвлөлөөс санал авч “Ес зүйн хороо”-гоор, шийдвэрлүүлэх ба шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандах саналыг хүргүүлнэ.



**УЛААНБААТАР ТЕАТР ОНӨТҮГ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 03 дугаар сарын 15

Дугаар 02

Улаанбаатар хот

Улаанбаатар театрын Захиргааны зөвлөлийн хурал 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 11:00 цагт даргын өрөөнд эхлэн 11:30 цагт дуусав

Хуралд:

R.Мөнхсайхан /дарга/
 Л.Одгэрэл /хүний нөөцийн менежер/
 П.Урнаа /өрөнхий найруулагч/
 С.Эрдэнэцэцэг /нягтлан бодогч/
 М.Энхтуул /Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн/
 Б.Өнөрцэцэг /дотоод ажил хариуцсан мэргэжилтэн/

Хэлэлцсэн нь:

1. НИТХ-ын тогтоолоор Улаанбаатар чуулга Улаанбаатар театр болж нэршил өөрчлөгдсөн учир байгууллагын үйл ажиллагаанд Дотоод хяналт шалгалт хийх журмыг өөрчлөн батлуулах тухай

Сонссон нь :

Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн М.Энхтуул
 Улаанбаатар театр болон нэршил өөрчлөгдсөнтэй холботойгоор театрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журмыг шинэчлэн батлуулах шаардлагатай байна. Иймд захиргааны зөвлөөс тусгах санал байвал шинэчлэн батлуулах журамдаа оруулж өгмөөр байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Хүний нөөцийн менежер Л.Одгэрэл

Нэршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус журмыг шинэчлэх нь зүй ёсны бөгөөд зөвхөн Дотоод хяналт шалгалтын журмаас гадна байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудыг бүхэлд нь шинэчлэх шаардлага гараад байгаа. Тухайлбал 2022 оноос мөрдөж эхлэх хуулийн үндэслэл өөрчлөгдсөн байгаа тул журмаа шинэчлэхдээх холбогдох хууль тогтоомжоос үндэслэлээ сайн шалгаарай.

Нягтлан бодогч С.Эрдэнэцэцэг

Нийслэлийн болоод хувийн аудитын шалгалтуудаар байгууллагын Дотоод хяналт шалгалтын ажлыг нэг бүрчлэн хянадаг учраас нэн даруй өөрчлөн батлуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Лапга R Мөнхсайхан

3140600020

За тэгвэл холбогдох хууль тогтоомж, үндэслэлээ судлаад дахин шинэчлэн батлуулахыг үүрэг Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн М.Энхтуулд үүрэг болгож байна.

Шийдвэрлэсэн нь:

Улаанбаатар театрын үйл ажиллагаанд Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журмыг шинэчлэн батлуулахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ДАРГА



Р.МӨНХСАЙХАН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН :

ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ӨНӨРЦЭЦЭГ

3
164

УЛААНБААТАР ТЕАТР ОНӨТҮГ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

doda оны 03 дугаар сарын 15

Дугаар 02

Улаанбаатар хот

Улаанбаатар театрны Захиргааны зөвлөлийн хурал 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 11:00 цагт даргын өрөөнд эхлэн 11:30 цагт дуусав

Хуралд:

Р.Мөнхсайхан /дарга/
Л.Одгэрэл /хүний нөөцийн менежер/
П.Урнаа /өрөнхий найруулагч/
С.Эрдэнэцэцэг /нягтлан бодогч/
М.Энхтуул /Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн/
Б.Өнөрцэцэг /дотоод ажил хариуцсан мэргэжилтэн/

Хэлэлцсэн нь:

1. НИТХ-ын тогтоолоор Улаанбаатар чуулга Улаанбаатар театр болж нэршил өөрчлөгдсөн учир байгууллагын үйл ажиллагаанд Дотоод хяналт шалгалт хийх журмыг өөрчлөн батлуулах тухай

Сонссон нь :

Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн М.Энхтуул
Улаанбаатар театр болон нэршил өөрчлөгдсөнтэй холботойгоор театрны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журмыг шинэчлэн батлуулах шаардлагатай байна. Иймд захиргааны зөвлөлөөс тусгах санал байвал шинэчлэн батлуулах журамдаа оруулж өгмөөр байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Хүний нөөцийн менежер Л.Одгэрэл

Нэршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус журмыг шинэчлэх нь зүй ёсны бөгөөд зөвхөн Дотоод хяналт шалгалтын журмаас гадна байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудыг бүхэлд нь шинэчлэх шаардлага гараад байгаа. Тухайлбал 2022 оноос мөрдөж эхлэх хуулийн үндэслэл өөрчлөгдсөн байгаа тул журмаа шинэчлэхдээх холбогдох хууль тогтоомжоос үндэслэлээ сайн шалгаарай.

Нягтлан бодогч С.Эрдэнэцэцэг

Нийслэлийн болоод хувийн аудитын шалгалтуудаар байгууллагын Дотоод хяналт шалгалтын ажлыг нэг бүрчлэн хянадаг учраас нэн даруй өөрчлөн батлуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ларга Р Мөнхсайхан

3140600019

За тэгвэл холбогдох хууль тогтоомж, үндэслэлээ судлаад дахин шинэчлэн батлуулахыг үүрэг Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн М.Энхтуулд үүрэг болгож байна.

Шийдвэрлэсэн нь:

Улаанбаатар театрын үйл ажиллагаанд Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ хийх журмыг шинэчлэн батлуулахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Р. Мөнхсайхан

Р.МӨНХСАЙХАН



ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН :

ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.Өнөрцэцэг